

“Орчин веййн дайн: шинжилгээ, онцлог, сургамж” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2012 оны 3 сарын 13-ны одор зохион байгуулж, явуулав. Хурлыг ЗХЖШ, БХИС, БХЭШХ хамтран зохион байгууллаа.

БХЭШХ-ийн Дайн, цэргийн урлаг судлалын товоос “Монгол цэргийн одрийг угтаж” дайн, цэргийн урлагийн асуудлаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг уламжлал тогтжээ. Энэ жилийн хурал 6 дахь удаагийнх болж байна.

Хуралд Монгол Улсын Үндэсний аюулгвй байдлын зовлолийн ажлын алба, Монгол Улсын Еронхийлогчийн тамгын газрын ажилтнууд, Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын удирдлага, ТЕГ-ын Үндэсний тагнуулын академи, Батлан хамгаалахын их сургууль, ХЗДХ-ийн яамны Дотоод хэргийн их сургууль, Хил хамгаалах еронхий газрын эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, багш сонсогчдын толоолол зэрэг 100 шахам хvн оролцов.

БХИС-ийн захирал Бригадын генерал З.Болдбаатар хурлын ажиллагааг нээж хэлсэн vгэндээ: “Дэлхийн II дайнаас хойш олон улсын хэмжээнд явагдсан олон дайнууд жижиг, бага идэвхжилтэй дайны шинж чанарыг оортоо агуулах болсон ба нэлээд тохиолдолд “партизаны дайн”-ы шинж чанартай, зонхилох ялалт тэдний талд болон оорчлогдсон, НҮБ-ын энхийн ажиллагааны цар хvрээ оргожиж, тvvнд дэлхийн улс гvрнvvдийн оролцоо, цэргийн дэмжлэг нэмэгдэх хандлагатай байгаа болон Монгол Улс НҮБ-ын энхийн ажиллагаанд идэвхтэй оролцож, Зэвсэгт хvчнээс олон талт vврэг гvйцэтгэх боломжоо нэмэгдvvлэх, сайжруулахыг шаардаж буйг цохон тэмдэглэв.

Энэ мэтээр дайны онол, орчин веййн дайн, энхийн асуудал нэлээд хувьсан оорчлогдсон богоод Зэвсэгт хvчний байгуулалт, цэргийн урлаг, цэргийн сургалт бэлтгэлд оорчлолт оруулахыг шаардаж байгааг дурдаад хурлын ажиллагаанд амжилт хvсэв”.

Хурлын vндсэн илтгэлийг ЗХЖШ-ын Еронхий зориулалтын цэргийн Командлагч бригадын генерал Р.Сvхбат, БХЭШХ-ийн Дайн, цэргийн урлаг судлалын товийн дарга, шинжлэх ухааны доктор, профессор Ш.Паламдорж нар: “Дайны тухай онол ба орчин веййн дайны

агуулгын хувьсал оорчлолт, онцлогийг шинжлэх нь” сэдвээр тавьж хэлэлцүүлэв. Түүнчлэн уг сэдвээр явуулсан судалгаануудыг үндэслэн оноо вед олон улс орон “хүйтэн дайн”-ы занал дор оршиж байгаа богоод түүний нэг нь Монгол Улс болоод байгаа тухай дүгнэлтийг хийсэн байна.

Хавсралт илтгэлийг доктор, профессор Б.Шагдар: “Орчин үеийн дайн, байлдаанд хуурай замын цэргийн гүйцэтгэх үүрэг”, Монгол Улсын гавъяат багш, доктор профессор Б.Түмэн: “Еронхий цэргийн операци, байлдааныг явуулах аргын хогжлийн талаарх үзэл баримтлал”, доктор, профессор Ч.Улаанхүү “Нисэх хүчнийг байлдаанд ашигласан сургамж, цаашдын хандлага”, доктор Л.Болдбаатар “Зенитийн пуужинт цэргийг байлдаанд ашигласан сургамж”, хурандаа С.Отгонбаяр “АДХЦ-ийн радиотехникийн цэргийн хогжлийн оноо ба ирээдүй”, Хурандаа С.Түвшинбаяр, дэд хурандаа Д.Содномцог нар: “Тусгай хүчний цэргийн үүрэг осож байгаа нь”, дэд хурандаа М.Золзаяа, доктор Ц.Эрдэнэ нар:” Мэдээллийн дайны бодит агуулга ба сургамж” сэдвүүдээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.